

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС 2014 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Авлигатай тэмцэх газар нь 2014 онд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг судалгааны үр дүнд суурилан тодорхой бодлого, чиглэлийн дагуу хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, албан тушаалтан авлига, ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлдэг, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүрт нь гаргадаг дадлыг хэвшүүлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн цахим бүрдүүлэлтийг төгөлдөршүүлэх, албан хаагчийн аюулгүй байдал, дотоодын хяналт шалгалтын үйл ажиллагааг төгөлдөршүүлэх, судалгаа дүн шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх, олон улсын туршлагад тулгуурлан судалгаа шинжилгээний ажлын аргачлалыг улам боловсронгуй болгох, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд хэлтэс, албадын хамтын ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, албан хаагчид, ажилтнуудын ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын чиглэлээр

Тайлангийн хугацаанд авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор төсвийн шууд захирагчийн эрх хэмжээний хүрээнд Тамгын хэлтсийн даргын 17 тушаал, Газрын даргын 235 тушаал батлагдсан 96 нь хүний нөөцийн чиглэлээр, 139 нь үйл ажиллагаатай холбогдон гарсан байна. Монгол Улсын Засгийн газраас төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэл өгсөнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/58 дугаар тушаалаар байгууллагын бүтцийн нэгжийн орон тоог шинэчлэн 5 хэлтэс, 6 алба, 172 албан хаагчтай байхаар тогтоон хэрэгжүүлж байна. Түүнчлэн байгууллагын даргын 2014 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн А/105 дугаар тушаалаар “Авлигатай тэмцэх газрын дотоод журам”-ыг шинэчлэн баталж, хэлтэс албадад хүргүүлэн, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу хөтөлж байгаа бөгөөд 2013 оны бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ. Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг боловсрол, ур чадвар, чадавхийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан 7 удаагийн сургалтад 177 албан хаагчийг хамруулсан.

Тайлангийн хугацаанд Төрийн нууцын зэрэглэлтэй 219, энгийн 13658 албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлж, тус газарт ирсэн Төрийн нууцын зэрэглэлтэй 238, энгийн 13300 албан бичгийг хүлээн авч Албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэл хөтлөн, цохолтын дагуу холбогдох албан хаагчдад бүртгэлээр шилжүүлэн үйл ажиллагаандаа ашиглах, хариуг хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны нөхцөлийг сайжруулах зорилгоор 59 ажилтан, албан хаагчид 2.0 тэрбум төгрөгийн, гэр хороололд энгийн галлагаатай гэр, байшинд амьдардаг 9 ажилтан, албан хаагчид өвлийн түлээ, нүүрс худалдан авахад нь зориулан тус бүр 250.000 төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүллээ.

Дотоод хяналт шалгалтын чиглэлээр ёс зүй, сахилгын зөрчил гаргасан 22 хүнд холбогдох 10 материалд албаны шалгалтыг хийж, шалгалтын дүнг байгууллагын ёс зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Үндсэн чиг үүргээ хариуцлагагүй гүйцэтгэсэн болон сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 1 албан хаагчид сануулах, 1 албан хаагчид үндсэн цалинг 1-3 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, 4 албан хаагчийг өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлсөн байна.

Тайлангийн хугацаанд газрын удирдлага болон нийт 50 албан хаагчийг Америкийн Нэгдсэн Улс, Бүгд найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Австри, Бүгд Найрамдах Солонгос, Сингапур, Япон, Турк, Арабын нэгдсэн Эмират, Франц, Оросын Холбооны Улс, Япон зэрэг улс, орнуудад авлигын эсрэг сургалт, олон улсын хурал, уулзалт, семинарт хамруулах ажлыг зохион байгууллаа. Гадаад орнуудын ижил төстэй хууль сахиулах байгууллагатай авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. БНХАУ-ын Ардын Ерөнхий Прокурорын газартай Харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулах албан ёсны айлчлал болон тус улсын Хяналтын яам /Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо/-ны дэд сайд, Төв хянан шалгах товчооны дарга тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалыг амжилттай зохион байгууллаа.

Шинээр баригдахаар төлөвлөгдөж буй 2 объектийн техникийн нөхцөлүүдийг холбогдох байгууллагуудаас авч, зураг төсөл, төсвийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэхэд шаардагдах арга хэмжээнүүдийг аваад байна.

2013 оны жилийн эцсийн болон 2014 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн төсөөллийг стандартын дагуу боловсруулж Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/, Улсын Их Хуралд тус тус хүргүүлж, 2013 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраар баталгаажуулах ажлыг зохион байгуулав.

Байгууллагын цайны газар, 16 автомашины дулаан гараж, хурлын болон тусгай бэлтгэлийн заал, архив, склад, сургалтын танхим зэрэг нийт 1136 м² зоорийн хэсэг бүхий 2 давхар барилгыг улсын комисст албан ёсоор хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан болно.

Байгууллагын “Амралт, сувиллын бичил бааз” байгуулах төсөл боловсруулж, газар эзэмших гэрчилгээ болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий дүгнэлт” гаргуулсан.

Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээ, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд үнэн бодитой, шуурхай мэдээлэх зорилгоор 6 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, 92 мэдээ бэлтгэн нийтлүүлж, зарим арга хэмжээг зөвхөн нэг удаа мэдээлээд орхилгүй цувралаар болон тодруулж мэдээлэх зэргээр олон нийтэд хүртээмжтэй, сонирхолтой байдлаар хүргэхэд анхаарч ажиллалаа. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хамгийн үнэн бодит, шуурхай хүргэх зорилгоор сар тутмын “Шинэ хуудас” мэдээллийн хуудсыг бэлтгэн хэвлүүлж төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтэд түгээсний Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг олон нийтэд энгийн хэлбэрээр ойлгомжтой харуулсан “Авлигатай тэмцэх газрын ажилтны нэг өдөр” телевизийн бүрэн хэмжээний нэвтрүүлгийг “Ардир медиа” студитэй хамтран бэлтгэж /“Ийгл”, “ТВ-10”, “ТВ-1”, “Үндэстэн”, “В”/ телевизээр цацуулав.

Авлигатай тэмцэх газрын 2010-2013 оны буюу сүүлийн 4 жилийн үйл ажиллагааны ололт амжилт, ахиц дэвшлийг харьцуулсан тоон мэдээлэл бүхий 3 төрлийн инфографикийг бэлтгэн /www.medee.mn, www.olloo.mn, www.sonin.mn, www.24tsag.mn, www.zaluu.com/ цахим хуудсаар флаш баннер хэлбэрээр хөдөлгөөнт сурталчилгаа хийж, олон нийтэд хүргэсэн.

Байгууллагын цахим хуудаснаас гадна байгууллагын Facebook, twitter хуудсуудыг давхар хөтлөн, Facebook хуудсанд 376 мэдээ, мэдээлэл оруулж,

дагагчдын тоо 2115 (2013 оны 12 дугаар сарын 30-нд 713 байсан)-д, Twitter хуудсанд 176 жиргээ бичиж, дагагчдын тоо 1240-д тус тус хүрсэн бөгөөд эдгээр хуудсуудаар 10 санал, хүсэлт ирүүлснийг удирдлагад танилцуулж холбогдох хэлтэст шилжүүлсэн болно.

Хоёр. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажиллагааны талаарх ойлголт мэдлэг, үнэлэмж, хүлээлтийг тодруулахад чиглэсэн судалгааг Хэвлэлийн Хүрээлэнгийн багаар хийлгэж судалгааны багаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн олон нийттэй харилцах стратегийг боловсруулан 2015 онд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаар зорьж байна.

Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр 20168 төрийн албан хаагч, иргэдэд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалтуудыг зохион байгуулсан.

Шударга нийгмийн төлөө хамтдаа аяны хүрээнд оюутан, залуучууд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, тэдний шинэлэг санааг түгээх, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эрдэм шинжилгээний бага хурал, Парламентын мэтгэлцээний тэмцээн, Зурагт хуудас бүтээх уралдааныг зохион байгуулж нийт 200 гаруй оюутан, залуучуудыг хамрууллаа.

Түүнчлэн хууль таниулах чиглэлээр гаргасан гарын авлагыг баяжуулан, холбогдох хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тусгаж “Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил, Ард олны ашиг өндөр тэнгэртэй адил”, “Нийтийн албан тушаалтны гарын авлага”, “Баадай болон түүний гэр бүлийн ашиг сонирхлын зөрчил” зэрэг гарын авлагыг 23500 ширхэг хэвлүүлэн төрийн байгууллага, иргэдэд тараав.

Авлигын хор хөнөөлийг олон нийтэд ойлгуулан, таниулах зорилгоор “Ус дээшээ урсдаг” телевизийн 28 ангит киног бүтээн “NTV” телевизээр олон нийтийн хүртээл болгосон бөгөөд авлигын бодит гэмт хэрэг дээр тулгуурласан “Төр түмэн нүдтэй” цуврал баримтат нийтлэлийн “Сүүдэр”, “Буруу урсгал”, “Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ” нэртэй 3 цувралыг бэлтгэн нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна.

Авлигыг мэдээлэх 18001969 дугаар бүхий утасны программ хангамжийг сайжруулах, олон нийтэд хүргэх сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх төслийг эхлүүлж, гурван шторкыг бүтээн олон нийтэд хүргэв.

Авлигын эсрэг олон улсын өдрийг “Сайн засаглалын сайн санаачилга 2014” сэдвийн дор амжилттай зохион байгуулж тус өдрийг угтан доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд, сурагчдад шударга ёсны тухай мэдлэг, чадвар эзэмшүүлэх, түүнийг эрхэмлэх үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор “Шударга ёс бидний тэмүүлэл” хичээлийн хөтөлбөр шалгаруулах уралдаан, дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Би дүүдээ шударга ёсыг тайлбарлаж өгсөн” эссе бичлэгийн уралдааныг тус тус зарлан шалгаруулан, “Авлига бол хүний эрхийн зөрчил” сэдэвт 4 бүлэг уншлагын тоглолттой бэсрэг жүжгийг найруулан тавиулж, “Транспэрэнси Монгол” төрийн бус байгууллагатай хамтран авлигын чиглэлээр хийгддэг гадаад, дотоодын судалгааны арга зүйг танилцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

Авлигын эсрэг олон улсын өдөр 12 дугаар сарын 9-нийг угтан хэрэгжүүлсэн ажлыг 1 телевиз /ТВ10/, 2 сонин /”Үндэсний шуудан”, “Өнөөдөр”/, 3 сайт /www.medee.mn, www.24tsag.mn, www.bataar.mn/-аар сурталчилсан нь иргэд олон нийтэд авлигын эсрэг дуу хоолойг хүргэхэд хэвлэл мэдээллийн байгууллагыг түлхүү ашиглах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг таниулах, хүүхэд, залууст шударга ёсыг эрхэмлэх дадал зуршлыг бий болгох, тэдэнд шударга ёс сэдвийн хүрээнд ойлголт өгөх зорилготой байлаа.

Төрийн байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн онцлогт зориулан тусгайлсан Зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. Энэхүү аргачлал нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн байгууллага болон авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх хөндлөнгийн шинжээчдэд гарын авлага болох төдийгүй авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийг татан оролцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг олгох нөхцөлийг бүрдүүлэхэд ахиц дэвшил авчирч байгаагаараа онцлогтой. Үнэлгээнд Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 16 яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 26 агентлаг, 22 аймаг, нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 44 хуулийн этгээд, нийт 124 байгууллага хамрагдаж, энэ жилийн улсын дундаж үнэлгээ 60%-тай байгаа нь өнгөрсөн онтой харьцуулбал 11.8%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний дүнтэй холбогдуулан аймгуудын Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, авлигын эсрэг үйл ажиллагааг

төлөвлөн хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилттэй нь танилцах, холбогдох хяналт шалгалтыг явуулах зорилгоор Баянхонгор, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл зэрэг аймгийн 123 суманд ажиллалаа. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах явцад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хуулиар хориглосон хандив зохион байгуулах, хууль тогтоомжоор тогтоосноос бусад нэмэлт төлбөр хураамж тогтоох, давхар ажил эрхлэлттэй холбогдох хязгаарлалт, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг зөрчих явдлууд нийтлэг байна.

Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, сургалт зохион байгууллаа.

“Монгол Улсад үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” Үндэсний хөтөлбөрийн баримт бичгийн төслийн үндэсний чуулганыг 1 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн ордонд “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”, НҮБ-тай хамтран зохион байгуулсан.

Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Өмчийн харилцааны газарт сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хамтдаа” төслийг эхлүүлж төслийн хүрээнд 28 ажил хэрэгжүүлэхээс өнөөдрийн байдлаар 23 ажил 100 хувь, 4 ажил хэрэгжих шатандаа 80 хувь, хэрэгжих хугацаа болоогүй 1 ажил байна. Төлөвлөгөө 97 хувийн биелэлттэй хэрэгжиж байна.

Чиг үүргийн дагуу Стандартчилал, хэмжил зүйн газар, Геологийн төв лаборатори, Татварын ерөнхий газар, Диспетчерийн үндэсний төв, Монголбанк, Хан-Уул дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, Сонгуулийн ерөнхий хороо, Тахарын ерөнхий газар, Геологийн төв лаборатори ТӨҮГ, Хүний эрхийн үндэсний комиссын ажилтны болон Боловсролын яамны багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 223 дугаар тушаалаар батлагдсан “Журам, төлбөрийн жишиг хэмжээг батлах тухай” журам, “Нийслэлийн өмчийн харилцааны газрын цахим хуудасны үйл ажиллагааны журам”, Сэлэнгэ аймгийн “Байгаль хамгаалах сан”-ын журмын төсөлд тус тус санал өгч ажиллалаа.

Нийт 27 өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр ажиллаж, зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авахуулан, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг хангах зорилгоор Конвенцийн 2 болон 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн үнэлгээ болон дотоодын хууль тогтоомжийн нийцлийн судалгааг хийлгэсэн. Хэлэлцүүлгээс гаргасан судалгаа, тайланг хамрах хүрээгээр нь ангилан холбогдох байгууллагуудад хүргүүлж, тэдгээр байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулан эхний уулзалтаа зохион байгууллаа. Мөн байгууллагын цахим хуудаст цонх нээн Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл байршуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулан, Улсын Их Хурал дахь авлигын эсрэг албан бус бүлгийн /МОНПАК/ гишүүдэд Манай улс дахь Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийн танилцуулгыг хүргүүлсэн.

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилгатай хамтран /StAR/ сургалт, уулзалт зохион байгуулж, гарын авлага боловсруулав. Тодруулбал, эрх зүйн харилцан туслалцааны заавар, аргачлалыг боловсруулах уулзалт, Хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр хийсэн семинар, Ахисан түвшний санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт, Эрх зүйн харилцан туслалцаа олон улсын хамтын ажиллагааны ахисан шатны сургалтыг зохион байгуулахад бүхий л чиглэлээр туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Түүнчлэн Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монголын авлигын индексийн судалгааны аргачлал болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн программ, маягтыг сайжруулах, Мөрдөн байцаагчийн ажилд зөвлөгөө өгөх гадаад дотоодын зөвлөхүүдийг урьж ажиллууллаа. “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтныг чадавхижуулах нь” сэдэвт сургалтыг орон нутагт хангайн, говийн, зүүн, баруун болон төвийн гэж бүсчлэн зохион байгууллаа.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, “Эмэгтэй удирдагч сан” төрийн бус байгууллагатай хамтран “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига” сэдэвт үндэсний чуулган зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж Эмэгтэй удирдагч сантай хамтран нийт 8 цуврал хэлэлцүүлгийг хуульч, сэтгүүлч, төрийн бус байгууллага, хуулийн төсөл боловсруулагч зэрэг бүлгүүдийн дунд зохион байгуулж, үндэсний чуулганаас гаргах нэгдсэн зөвлөмжийн төсөлд санал боловсруулан ажиллаж байна.

Гурав. Судалгаа, шинжилгээний чиглэлээр

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Улсын Их Хурал авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар

Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр мэдээлнэ” гэж заасны дагуу “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээллийг байгууллагын хэлтэс, албадын үйл ажиллагааны тайлан, гадаад, дотоодын авлигын талаарх судалгааны үр дүнгийн хүрээнд боловсруулан, хэвлэж, Улсын Их Хуралд хүргүүлэв.

Авлигын эсрэг хуульд заасны дагуу авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судлан 2013 оны авлигын индексийг гаргаж, судалгааны үр дүнгийн тайланг хураангуй болон дэлгэрэнгүй хэлбэрээр боловсруулж, байгууллагын цахим хуудсанд англи, монгол хэлээр байршуулсны зэрэгцээ 3000 ширхгийг хэвлүүлэн түгээж, төрийн байгууллагууд дахь авлигын нөхцөл байдал, шалтгааны талаар төрийн албан хаагчид, салбар яам, бүх шатны шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч, улс төрийн нам, төрийн бус байгууллагын төлөөлөл, сэтгүүлч, иргэдэд танилцуулах ажлыг 14 удаа зохион байгуулж, судалгааны үр дүнгийн талаар телевиз, радиод ярилцлага өгч олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. Мөн Авлигын индексийн өмнөх судалгааны дүнгээр орон нутгийн хэмжээнд тайлан гаргаж байгаагүйг харгалзан аймаг бүрээр авлигын шалтгаан, нөхцөлийн талаар тусгайлан танилцуулга боловсруулж, хүргүүлэн, Нийслэл болон Сэлэнгэ, Завхан, Ховд, Хөвсгөл аймагт уулзалт, сургалт, семинарыг зохион байгуулж, 1100 орчим хүнийг хамруулан танилцуулсан нь авлигын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, авлигын эсрэг арга хэмжээг оновчтой төлөвлөх, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болсон гэж дүгнэж байна.

Авлигын индексийг тооцох аргачлал, асуулгын хуудсыг боловсронгуй болгох зорилгоор Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явуулж үндэсний 4 шинжээч-зөвлөхийг шалгаруулан ажиллуулав. Энэ ажлын хүрээнд авлигын индексийн судалгаанд ашигладаг иргэдийн төсөөллийн судалгаа, төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаа, бизнес эрхлэгчдийн төсөөллийн судалгаа, шинжээчдийн төсөөллийн судалгааны асуулгын хуудас болон түүнийг нөхөх заавар, судалгааны удирдамж болон индексийн тооцооны аргачлалыг шинэчлэн боловсруулсан бөгөөд онлайн хэлбэрээр туршилт, судалгаа явуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заагдсан “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн байгууллагын шударга байдлын түвшний 2014 оны судалгааг Баянхонгор, Говь-Алтай, Увс, Орхон, Говьсүмбэр зэрэг 5 аймаг

болон нийслэлийн хэмжээнд, төрийн үйлчилгээний 10 салбараар үйлчлүүлсэн 3765 иргэнийг хамруулан зохион байгуулж, судалгааны тайланг боловсруулан хэвлүүлж олон нийтэд түгээхэд бэлэн болоод байна. Энэ удаагийн судалгааны тайланд төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлж буй 13 үзүүлэлтийг салбар тус бүрээр тусгаж харуулснаар судалгаанд хамрагдсан салбаруудад ямар нөхцөл байдал, үзүүлэлт нөлөөлснөөс болж шударга байдлын түвшин өөрчлөгдөж буйд дүгнэлт хийж болох боломж бүрдсэн болно.

Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу 2008 оноос эхлэн зохион байгуулж байгаа Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг энэ онд 2 удаа зохион байгууллаа. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааг 2008 оноос хойш албан ёсны асуулга, заавар, аргачлалгүйгээр зохион байгуулж байсан. Иймд Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны удирдамж, үзүүлэлтүүдийн тооцооны аргачлал, асуулгыг боловсруулж Газрын даргын тушаалаар батлуулан түүний дагуу 2014 оны судалгааг зохион байгуулж, тайланг боловсруулан олон нийтэд хүргэхэд бэлэн болголоо. Энэ оны судалгааны дүнгээр “Дээд” түвшний авлигын үзүүлэлт 3.58 буюу өмнөх судалгааны дүнгээс 0.10 пунктээр буурсан сөрөг үзүүлэлттэй гарсан нь шинжээчдийн төсөөллөөр Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига түгээмэл байгааг илтгэж байна.

Хүүхдийн шударга байдлын түвшин болон хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид тэдгээрийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор Хүүхдийн шударга байдлын 2014 оны судалгааг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран улсын хэмжээнд зохион байгуулан, судалгааны тайлан бэлтгэсэн бөгөөд 2014 оны судалгаагаар Хүүхдийн шударга байдлын түвшин 4.03 гэсэн дүнтэй гарч өмнөх оныхоос 0.32 пунктээр өссөн болон хүүхдийн шударга байдалд эцэг, эх, болон сургуулийн орчин, мэдээлэл хүлээн авч байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцоо чухал нөлөөтэйг онцлон олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Судалгаа шинжилгээний энэ оны үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь шинээр болон шинэчлэн боловсруулж буй болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, эрх зүйн актын төсөлд санал өгөх, холбогдох судалгааг гүйцэтгэж танилцуулах, бусад нэгжээс төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах ажил байсан бөгөөд

тайлангийн хугацаанд Шилэн дансны тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай, Өршөөл үзүүлэх тухай, Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөлд санал өгч ажиллав.

Түүнчлэн Гэрч, хохирогчийг аюулгүй газар түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам, Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, Гэрч хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, Малайз Улсын Засгийн газартай байгуулах гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээний төсөл, Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн төсөл зэрэг шинээр боловсруулсан журам, гэрээний төсөлд тус тус санал өгч ажиллалаа.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд эдгээр хуулийн өөрчлөлтүүдийг 2014 оны нэгдүгээр сард УИХ-аас баталсан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд нийт 38 улсын 39 авлигатай тэмцэх үндэсний стратеги, бодлого зэргийг судлан эмхэтгэл бэлтгэсэн бөгөөд Армен, Болгар, Эстон, Гана, Индонез, Серби, Уганд, Бутан, Өмнөд Африк, Тайланд зэрэг улсын авлигатай тэмцэх үндэсний бодлого, стратеги, хөтөлбөр, авлигын эсрэг хуулийг орчуулан, санал боловсруулав. Мөн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг ажлын хэсгийн хамт шинээр боловсруулан, Иргэний танхимд хэлэлцүүлэн, улмаар хөтөлбөрийн төслийг 3 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн болно.

Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу 2014 оны эхний 3 улирлын өргөдөл, гомдол, мэдээлэлд шинжилгээг хийж, тайлан боловсруулан удирдлагад тухай бүр танилцуулан ажиллалаа. Өргөдөл, гомдол,

мэдээллийн шинжилгээг бусад хэлтсээс ирүүлсэн мэдээнд үндэслэн хийж ирсэн бөгөөд холбогдох мэдээллүүд хоцорч ирж байснаас цаг алдах, шинжилгээний ач холбогдол буурах зэрэг хүндрэл учирч байсны зэрэгцээ байгууллагад ашиглаж буй бүртгэл мэдээллийн системээс хамаарч өргөдөл, гомдол, мэдээллийн шинжилгээг иж бүрэн байдлаар хийх боломжгүй байсныг харгалзан дүн шинжилгээ хийхэд зайлшгүй шаардлагатай өгөгдөл, санал боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон улсад мэдээлэгдсэн авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар болон ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс ирүүлсэн бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж удирдлагад тухай бүр танилцуулсан.

БНХАУ, ОХУ, Тайландын Вант Улсын авлигын нөхцөл байдал, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, сүүлийн үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэргүүн туршлагыг судлан, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласны зэрэгцээ авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх гадаад мэдээ, нийтлэл, үйл явдлыг 7 хоног бүрээр түүвэрлэн орчуулж, нийт 50 удаагийн тойм мэдээ бэлтгэн, танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллав.

Тайлангийн хугацаанд зохион байгуулсан 70 гаруй судалгаа, шинжилгээний тайланг танилцуулга хэлбэрээр бэлтгэж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав. Тухайлбал, авлигад өртөх эрсдэл өндөртэй байгууллага, албан тушаалтны талаар дотоод, гадаадын судалгааны үр дүн болон улс орнуудын туршлага, өндөр түвшний авлигатай тэмцэхэд бусад улс орнуудын тэргүүн туршлага, сургамж болон Монгол улс дахь нөхцөл байдал, боловсролын салбарт авлига үүсэхэд нөлөөлж болох хүчин зүйлс, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, бусад улс орнуудын туршлага, цаашид анхаарах асуудал, худалдан авах ажиллагааны талаар бусад улс оронд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, улс орнууд дахь парламентын гишүүдийн ёс зүйн шаардлага, парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны журам, авлигын талаарх судалгааны дүн, бусад улс орнууд сонирхлын зөрчлийг хэрхэн зохицуулж байгаа болон сонирхлын зөрчилд хүлээлгэх хариуцлага, зарим улс орны хөрөнгө, орлогын мэдүүлгийн систем, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид заагдсан авлигын эсрэг хууль сахиулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага байгуулах талаарх заалттай холбоотой танилцуулга болно.

“Шударга ёс” онол, арга зүйн цувралыг бэлтгэх ажлыг хариуцсан редакцийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн хурлыг зохион байгуулан нийтлэлийн

бодлогыг хэлэлцүүлэн, сэтгүүлд тавигдах материалыг бэлтгэж редакцын зөвлөлийн гишүүдээр хянуулан цувралыг хэвлүүлж, олон нийтэд түгээж байна.

**Дөрөв. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө,
орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт хяналт
шалгалтын чиглэлээр**

Тайлангийн хугацаанд нийтийн албан тушаалтнуудын 2013 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн тойм мэдээ болон бүрдүүлэлтийн тайлангийн нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тус тус хүргүүлэв.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулах зорилгоор танилцуулга, холбогдох судалгааг гаргаж тус байнгын хорооны ажлын хэсэгт танилцуулж батлуулсан.

Тайлангийн хугацаанд 2013 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлбэл зохих 266 мэдүүлэг гаргагч 100 хувь мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн бөгөөд 2014 онд шинээр 24 албан тушаалтан томилогдож Авлигын эсрэг хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 11 мэдүүлэг гаргагч шинээр нэмэгдэж, 22 албан тушаалтан их хэмжээний өөрчлөлтөө бүртгүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг 239 албан тушаалтны 2013 оны мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, www.xacxom.iaac.mn цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй болгов.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 112 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2014 оны тайлан мэдээг гаргуулан авч нэгтгэсэн бөгөөд улсын хэмжээнд 51584 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 51579 мэдүүлэг гаргагч буюу 99,99 хувь нь бүртгүүлсэн бөгөөд 21828 буюу 42,32 хувь нь Улаанбаатар хотод, 29751 буюу 57,68 хувь нь орон нутагт байна. Нийт мэдүүлэг гаргагчаас 51573 мэдүүлэг гаргагч буюу 99,98 хувь нь хуульд заасан хугацаандаа, 6 мэдүүлэг гаргагч буюу 0,01 хувь нь хугацаа хожимдуулж мэдүүлсэн бол 5 мэдүүлэг гаргагч буюу 0,01 хувь нь мэдүүлгээ огт гаргаж өгөөгүй байна. Мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан 11 мэдүүлэг гаргагчид Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах, мэдүүлгийг нь нөхөн гаргуулахаар удирдах албан

тушаалтнуудад албан бичиг хүргүүлсний дагуу 6 албан тушаалтанд холбогдох арга хэмжээг авахуулсан байна.

Мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан мэдүүлэг гаргагчаас төрийн тусгай албан хаагч 2, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч 1, төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан 4, төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ын хараат бус гишүүн 3, төрийн үйлчилгээний байгууллагын удирдах 1 албан тушаалтан байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын хүрээнд төрийн 76 байгууллагын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт явуулав.

Хяналт шалгалтын чиглэлээр 2528 мэдүүлэг гаргагчийн 2012, 2013 оны мэдүүлэгт хяналт хийж, мэдүүлгээ хуульд заасан хугацаандаа мэдүүлээгүй, хожимдуулж мэдүүлсэн 260 албан тушаалтанд сахилгын арга хэмжээг авахуулж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулалгүй томилогдсон 771 албан тушаалтны томилгоог хүчингүй болгуулав.

2013 оны мэдүүлгийн бүрдүүлэлтээр төрийн болон нутгийн захиргааны төв 112 байгууллага бүртгэлтэй байсан бөгөөд 2014 онд 115 болж, 1628 эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн байна. Үүнээс 120 эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн байгууллагуудад 1508 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгаагийн 25 хувь нь нийслэлд, 75 хувь нь орон нутагт байна. Өнгөрсөн жилийн судалгаанаас эрх бүхий албан тушаалтны тоо нэмэгдсэн нь бүх аймаг, дүүргийн худалдан авах ажиллагааны алба, 9 дүүргийн боловсролын хэлтэс, 21 аймгийн төрийн банкны салбар болон Нийгмийн даатгал, Хөдөлмөрийн яамны харъяа нэгжүүдэд эрх бүхий албан тушаалтан шинээр томилогдсонтой холбоотой.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд нийт 121 байгууллагын 2130 эрх бүхий албан тушаалтан, 6568 мэдүүлэг гаргагч, нийт 8553 хүн /давхардсан тоогоор/-ийг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажилласан ба Нутгийн удирдлагын холбооны шугамаар 22 удаа, Азийн сан, Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөс хамтран зохион байгуулж буй “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сэдэвт сургалтыг 7 удаа, “ЭБАТ-тай ярилцах цаг” сургалтыг Улаанбаатар хотод 4 удаа, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт тус бүр 1 удаа зохион байгуулсан байна.

Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулж мэдээ, мэдээлэл, туршлага солилцох зорилгоор ЭБАТ Facebook хаягийг нээн ажиллуулж байгаа ба одоогоор 456 эрх бүхий албан тушаалтан гишүүнээр бүртгүүлсэн.

2014 онд Ховд, Архангай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Улаанбаатар гэсэн 6 бүсэд сургалт зохион байгуулж төрийн байгууллагын салбар, нэгжүүдэд ажиллаж байгаа нийт 1175 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг анх удаа бүсчилэн хамруулсан нь ихээхэн онцлогтой, ач холбогдолтой, үр дүнтэй сургалт боллоо.

Тайлангийн хугацаанд нийт 561 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаас 450 мэдүүлгийг шалгаж дууссан ба 111 албан тушаалтны мэдүүлгийг шалгаж байна. Нийт шалгасан мэдүүлгийн 361 буюу 80,4 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 48 буюу 10,6 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 40 буюу 9 хувийг тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр шалгасан байна.

Мэдүүлгийн хяналт шалгалтын дүнгээр хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн албан тушаалтны тоо 2014 онд 2013 оныхоос 54-өөр, зөрчилгүй албан тушаалтны тоо 83-аар тус тус буурсан байна.

Тайлант хугацаанд нийт 317 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас 283-ыг хянан шийдвэрлэж, 40 нь ажиллагаанд хянагдаж байна. Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн 194 буюу 61 хувийг хувь хүн, иргэнээс, 103 буюу 32.5 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгжээс, 10 буюу 3 хувийг бусад байгууллагаас, 10 буюу 3 хувийг нэр хаяг нь тодорхойгүй гомдол, мэдээлэл эзэлж байгаа бөгөөд нийт өргөдөл, гомдлын 146 буюу 46 хувийг нийслэл хотоос, 171 буюу 54 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн байна.

2014 оны тайлант хугацаанд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 13226 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 12940 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн бөгөөд одоо 286 мэдүүлэг хянагдаж байна.

Хянасан хариу хүргүүлсэн урьдчилсан мэдүүлгээс Ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан нийт 3344, хянах боломжгүй үндэслэлээр 1000 мэдүүлгийг буцаан хүргүүлж, албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон 1225 тушаал, шийдвэрийг хүчингүй болгуулж, 162 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэв.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2736 мэдүүлгээр буюу 26,4 хувиар нэмэгдсэн, ашиг сонирхлын

зөрчил үүссэн нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан болон зөрчилтэй гэдгийг тогтоосон чанарын үзүүлэлт дээшилсэн байна.

Тайлангийн хугацаанд Авлигын эсрэг хууль тогтоомж, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд түгээмэл гарч буй зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсний дагуу холбогдох арга хэмжээг авахуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулан 367 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 212-оор буюу 2.36 дахин их байна.

Хариуцлага тооцуулсан байдлыг шалгалтын төрөл бүрээр үзүүлбэл:

№	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрлөөр			Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо, бүгд
		ХАСМХОМ-ийн хяналт шалгалтаар	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	ХАСМХОМ-ийн бүрдүүлэлтийн хяналтаар	
1	Сануулсан	15	2	251	268
2	Цалинг бууруулсан	24	17	20	61
3	Албан тушаал бууруулсан	1	4	0	5
4	Ажлаас халсан	5	22	6	33
	Дүн	45	45	277	367

Тав. Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр

Тайлангийн хугацаанд нийт 781 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 498 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 2013 оны мөн үетэй харьцуулахад 18.0 хувиар өссөн байна.

Урьд оны үлдэгдэл 19 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 498 гомдол, нийт 517 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 89 гомдол, мэдээлэл буюу 17.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувиар өссөн, 323 гомдол, мэдээлэл буюу 62.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.3 хувиар өссөн, 90 гомдол, мэдээлэл буюу 17.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 3 гомдол, мэдээллийг нэгтгэн шалгасан бөгөөд ажиллагаанд 12 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 97.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өссөн байна.

Нийт шалгасан гомдол, мэдээллийн 322 буюу 62.3 хувь нь Улаанбаатар хотын, 195 буюу 37.7 хувь нь орон нутгийн харьяалалтай байна.

Гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь авч үзвэл бичгээр буюу шуудангаар 307, утсаар 17, интернетээр 10, биечлэн 163 гомдол, мэдээлэл иржээ.

Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 598 холбогдогч, 721 үйлдэлтэй 239 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2013 оны мөн үетэй харьцуулахад 27.8 хувиар өссөн байна.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилвал:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 58 буюу 24.3 хувь,

- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 29 буюу 12.1 хувь,

- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 20 буюу 8.4 хувь,

- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 8 буюу 3.3 хувь,

- хээл хахууль авах 33 буюу 13.8 хувь,

- хээл хахууль өгөх 26 буюу 10.9 хувь,

- хээл хахуульд зуучлах 11 буюу 4.6 хувь,

- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 16 буюу 6.7 хувь,

- хууль бусаар хөрөнгөжих 1 буюу 0.4 хувь,

- мөнгө угаах 5 буюу 2.1 хувь,

- бусад хэрэг 32 буюу 13.4 хувийг эзэлж байна.

Зүйлчлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 12 хэргээр буюу 17.1 хувиар буурсан, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 4 хэргээр буюу 16 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 1 хэргээр буюу 5.3 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 7 хэргээр, хээл хахууль авах 11 хэргээр буюу 50 хувь, хээл хахууль өгөх 6 хэргээр буюу 20 хувь, хээл хахууль зуучлах 3 хэргээр буюу 37.5 хувь, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 10 хэргээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 69 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 28.9 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.0 хувиар өссөн, 48 хэргийг буюу 20.1 хувийг

хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 хувиар буурсан, 47 хэргийг буюу 19.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өсөж, 19 хэргийг буюу 7.9 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 14 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлж, одоо 42 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэрэгт нийт 598 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.5 хувиар өссөн, хэргийн холбогдогчдыг албан тушаалын байдлаар нь авч үзвэл улс төрийн албан тушаалтан 45 буюу 7.5 хувь, төрийн захиргааны албан тушаалтан 141 буюу 23.6 хувь, төрийн тусгай 58 буюу 9.7 хувь, төрийн үйлчилгээний 48 буюу 8.0 хувь, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын албан тушаалтан 90 буюу 15.1 хувь, гадаадын иргэн 9 буюу 1.5 хувь, бусад 207 буюу 34.6 хувийг эзэлж байна.

Эрүүгийн хэрэгт шалгагдсан холбогдогч нарыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төрийн улс төрийн албан тушаалтан 10 буюу 28.6 хувиар, төрийн захиргааны албан тушаалтан 56 буюу 65.9 хувиар, төрийн тусгай албан тушаалтан 12 буюу 26.1 хувиар, төрийн үйлчилгээний албан тушаалтан 6 буюу 14.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 61 тэрбум 145.5 сая төгрөгийн хохирол учирснаас 4 тэрбум 858 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 17 тэрбум 355.7 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан байна.

Анхан шатны шүүхээс 18.691.229.940 төгрөгийг улсын орлого болгох шийдвэр гарсан дүнтэй ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Тайлангийн хугацаанд Авлигатай тэмцэх газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжсэн, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.

Байгууллагын зүгээс авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээ нэг бүрийг олон нийтэд мэдээлэхэд түлхүү анхаарч ажилласан нь мэдээллийн урсгалыг тогтмолжуулж, гаргаж байгаа мэдээллүүд нь байгууллага руу чиглэсэн сөрөг мессеж, мэдээллийг сарниулахад тодорхой байдлаар нөлөөлсөн.

Олон нийттэй харилцах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээ хийлгэж, тус үнэлгээний үр дүнд суурилан

дотоодын зөвлөх ажиллуулж, тус газрын олон нийттэй харилцах 2015-2017 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан гаргалаа.

Авлигатай тэмцэх газраас төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, хувийн хэвшилтэй үр дүнтэй хамтран ажиллах эхлэлийг амжилттай тавилаа.

Авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох талаар судалгаа шинжилгээний ажлууд тогтмол зохион байгуулагдаж байгаа боловч судалгааны үр дүнг ашиглах, судалгаанд суурилж үйл ажиллагаагаа төлөвлөн, зохион байгуулах явдал хангалттай бус байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

Ховд, Архангай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Улаанбаатарт бүсчилсэн сургалтыг зохион байгуулж төрийн байгууллагын салбар, нэгжүүдэд ажиллаж байгаа нийт 1175 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан нь ихээхэн онцлогтой, ач холбогдолтой, үр дүнтэй сургалт болсон гэж дүгнэж байна.

Эрх бүхий албан тушаалтнууд нилээд шинэчлэгдэж, 2012 оны сонгуулийн үр дүнд яам, агентлаг, орон нутагт ихээхэн өөрчлөлтүүд орсноор бүрдүүлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, тайлан мэдээ гаргахад хүндрэл учирч байгаа нь шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудыг байнга сургаж, мэргэжүүлэх зайлшгүй шаардлага гарч байгааг харуулж байна.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар шалгасан нийт 450 албан тушаалтны мэдүүлгийн 339 буюу 97,7 хувийг 30-60 хоногт шалгасан ба хугацаа хэтрүүлж шалгасан мэдүүлгийн тоо өмнөх онтой харьцуулбал 116-гаар буурсан нь мэдүүлгийг шалгах ажлын үзүүлэлт сайжирсан байна.

Түүнчлэн 2014 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 12940 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 26,4 хувиар нэмэгдсэн төдийгүй ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан болон зөрчилтэй гэдгийг тогтоосон чанарын үзүүлэлт дээшилсэн байна.

Олон үйлдэл, эзэн холбогдогчтой, зохион байгуулалттай, анхаарал татсан эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэхэд мөрдөн байцаагч нар ажлын хэсгээр буюу багаар ажиллах нь ихээхэн үр дүнтэй байна. Мөн санхүүгийн чиглэлээр мэргэшсэн мөрдөн байцаагчийг томилуулан ажиллуулснаар санхүүгийн баримтаар халхавчилсан хууль бус үйлдлүүдийг богино хугацаанд үр дүнтэй илрүүлж, шалгаж шийдвэрлэхэд ахиц гарахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хийгдсэн хяналтын камер, компьютер, сервер, сүлжээ, програм хангамж бусад мэдээллийн технологийн чиглэлийн шинэчлэлт, сайжруулалтын ажлууд нь албан хаагч болон мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, мэдээлэл алдагдах сувгийг тодорхой хэмжээгээр хааж, ажлын бүтээмжид сайнаар нөлөөлсөн.

САНАЛ

Газрын үйл ажиллагаанд нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийг зөв тооцоолж дүрэм журмаа шинэчлэх, хүний нөөцийг чадавхижуулах, санхүү, аж ахуйн хувьд бэхжих, олон нийтэд зөв хүрч, ажлаа ойлгуулах асуудал чухлаар тавигдаж байна. Байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэх ажлыг зөвхөн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хязгаарлахгүй, иргэд олон нийтэд шууд чиглүүлэн хүргэхэд анхаарч, нийгмийн мэдээллийн сүлжээг улам түлхүү ашиглах шаардлагатай байна.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийн сайжруулснаар “Судалгаа шинжилгээний програм”-ыг бүрэн ашиглаж мэдүүлэг гаргагчдын 2013, 2014 оны мэдүүлгийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, судалгааны жижиг товхимол хэвлүүлэх, судалгаа шинжилгээний чиглэлээр мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээс сургалт авах ажлыг зохион байгуулах шаардлага байна.

Цаашид төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллага, салбар нэгжийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг хамруулсан бүсчилсэн сургалтыг тогтмол зохион байгуулж, “ЭБАТ-тай ярилцах цаг”-т эрх бүхий албан тушаалтнуудыг байнга оролцуулж, энэ үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж хэвшүүлэх, хяналт шалгалтын чиглэлээр бүртгэлийн байгууллагуудын бүртгэлийг өөрийн мэдээллийн баазад холбож лавлагаа мэдээллийг шуурхай авах боломжийг бүрдүүлэх, орон нутагт ажиллах багасгаж, өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан мэдээлэлдээ үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг бууруулах зорилгоор аливаа эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж санал боловсруулах ажилд түлхүү анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Байгууллагын 2015 онд дэвшүүлэх ЗОРИЛТ

1.Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг шинэ шатанд гаргах, дотоод, гадаад сургалтыг үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүнг сайжруулах, соён гэгээрүүлэх ажлыг зорилтот бүлэг бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад үндэслэн зохион байгуулж чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.Аливаа судалгаа шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, арга зүйн дагуу цахим технологид тулгуурлан, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхэд ашиглах, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлэх;

4. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, цахим мэдээллийн санд үндэслэн судалгаа, дүн шинжилгээ хийх, хяналт шалгалтын ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг багасгах, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээг авч, үр дүнд хүрэх;

5.Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, хуульч шуурхай ажиллагааг эрхэмлэж, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх;

6.Хууль дээдлэн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллахад анхаарч, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР